



БУЛГАН АЙМГИЙН БҮРЭГХАНГАЙ СУМЫН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2025 оны 07 сарын 01 өдөр

Дугаар 1/06

Дархан баг

Г Төрийн албаны хүний нөөцийн  
дэд хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3, 35 дугаар зүйлийн 35.1.8, 35.1.13, 48 дугаар зүйлийн 48.1, Төрийн албаны тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.3, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ес дэх удаагийн сонгуулийн 2024 оны II хуралдааны II/03 дугаар тогтоолоор батлагдсан “Бүрэгхангай сумын Засаг даргын 2024-2028 оны “Хөгжлийг түүчээлье” үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.6 дахь заалтыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ес дэх удаагийн сонгуулийн ээлжит V хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Бүрэгхангай сумын төрийн албаны хүний нөөцийн дэд хөтөлбөр (2025-2030 он)-ийг хавсралтаар баталсугай.


2. Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлан, төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, санхүүжилтийг улс, орон нутгийн төсөв, сумын хөгжлийн төлөвлөгөөнд жил бүр тусган, хэрэгжилт үр дүнг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнаж ажиллахыг сумын Засаг дарга (Э.Эрдэнэбулган)-д даалгасугай.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын чиг үүргийн Хороод, Зөвлөл, Хурлын нарийн бичгийн дарга (И.Ичинхорлоо) нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



Н.ЭРХЭМБАЯР



## БҮРЭГХАНГАЙ СУМЫН ТӨРИЙН АЛБАНЫ ХҮНИЙ НӨӨЦИЙН ДЭД ХӨТӨЛБӨР (2025-2030 ОН)

### НЭГ. ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА:

Төрийн албаны чиг, үүрэг, зарчмын эрс шинэчлэл хийгдэж, албан тушаалд тавигдах шаардлага, төрийн албан хаагчийн эрх зүйн байдал, төрийн алба хаах болзол, журам, нийгмийн баталгааны талаарх олон асуудлыг хууль, журмаар зохицуулж өгсөн боловч хүний нөөцийг бүрдүүлэх, сургах, бэлтгэх, сонгон шалгаруулах үйл явц асуудалтай хэвээр байна.

Хүний их эмч, сувилагч, багш, төрийн захиргааны зарим мэргэжилтний дутагдлаас шалтгаалан төрийн байгууллагын үйл ажиллагаанд чанарын доголдол үүсэж байна.

Бүрэгхангай сумын төрийн албан хаагчдын дунд явуулсан санал асуулга, судалгааны үр дүнд хэрэгцээ шаардлагаа тодорхойлон Төрийн албаны хүний нөөцийн дэд хөтөлбөрийг боловсрууллаа.

### ХОЁР. СУМЫН ТӨРИЙН АЛБАНЫ ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ:

Бүрэгхангай сумын хэмжээнд 6 байгууллагад 124 төрийн албан хаагч ажиллаж байна. Үүнээс:

- Улс төрийн 7, төрийн захиргааны 14, төрийн үйлчилгээний 103
- Боловсролын түвшингээр нь авч үзвэл магистр-7, бакалавр-81, бүрэн дунд 31, бүрэн бус дунд боловсролтой 5
- Хүйсийн хувьд эмэгтэй 103, эрэгтэй 21 албан хаагч ажиллаж байна.

Сумын хэмжээнд өнөөдрийн байдлаар 25 сул орон тоо дутагдалтай байгааг байгууллага тус бүрээр нь авч үзвэл:

Нархан цэцэрлэг	Эрүүл мэндийн төв	ЕБС	ЗДТГ
• эрхлэгч 1,	• Шүдний эмч 1,	• Химийн багш 1,	• Байгаль орчин 1
• эмч 1,	• Эмч 1,	• Англи хэлний багш 1,	• Нийгмийн бодлого 1,
• жижүүр 1,	• Эх баригч эмч 1	• Монгол хэлний багш 1	• Олон НБ 1
• манаач 3,	• Сувилагч 2,	• Математикийн багш 1,	• ОНЦ 1,
	• Лаборант 1,	• Дотуур байрны багш 1	• Сласарь, манаач 1,
		• Сэтгэл зүйч 1	
		• Бага ангийн багш 2	



**20** их, дээд сургуульд  
**32** мэргэжлээр

	Нийт	ЮРС						Бусад
		1	2	3	4	5	6	
МУВИС	10	3	4	2	1			
ШУТИС	7	1	2	2	2			
АУШУИС	11	3	3	3	1		1	
ХААИС	10	2	1	5	2			
ИЗИС	8	3	1	2	1	1		
Гадаад	13	4	5	2	2			
<b>Бусад</b>	<b>22</b>	<b>1</b>	<b>4</b>	<b>2</b>	<b>9</b>	<b>1</b>	<b>5</b>	
	<b>81</b>	<b>17</b>	<b>20</b>	<b>18</b>	<b>18</b>	<b>2</b>	<b>1</b>	<b>5</b>



Тодорхойгүй 5

## ГУРАВ. ХӨТӨЛБӨРИЙН ЭРХ ЗҮЙН ҮНДЭС:

- 3.1. Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин зургаадугаар зүйлийн 3 дахь хэсэг,
- 3.2. Төрийн албаны тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.3 дахь заалт,
- 3.3. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын Хоёрдугаар бүлэг, хүний хөгжил зорилт,
- 3.4. Улсын Их Хурлын 2021 оны 106 дүгээр тогтоолоор батлагдсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ын 6 дахь багц асуудал болох Төрийн бүтээмжийн сэргэлтийн бодлого
- 3.5. Холбогдох бусад эрх зүйн акт зэргийг үндэс болгов.

## ДӨРӨВ. ҮНДСЭН ЗАРЧИМ:

4.1. Төрийн албаны нөөцийг бүрдүүлэх, сонгон шалгаруулах, төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, баталгаагаар хангах үйл явцыг удирдан зохион байгуулах, сахин хэрэгжүүлэхэд албан хаагч бүр төрийн албаны үндсэн зарчмыг баримтлахаас гадна иргэдийн нийтлэг эрх ашгийг хүндэтгэсэн шударга, энэрэнгүй, санал, санаачилгатай байх зарчмыг баримтална.

## ТАВ. ХҮНИЙ НӨӨЦ ДЭД ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ:

### 5.1. Зорилго:

Бүрэгхангай сумын төр, төсвийн байгууллагуудыг үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд хүний нөөцийн хэрэгцээ, шаардлагыг хангах, ёс зүйтэй төрийн албыг төлөвшүүлэх, гүйцэтгэл, үр дүнг сайжруулах. төрийн албан хаагч тогтвор суурьшилтай ажиллах таатай, орчин нөхцөлийг бий болгох, сургах, бэлтгэх үйл явцыг салбарын хүний нөөцийн бодлогоор зохицуулахаас гадна энэхүү дэд хөтөлбөрөөр оновчтой зохицуулах, санхүүжүүлэх, ухаалаг технологи нэвтрүүлэхэд оршино.

### 5.2. Зорилт:

5.2.1. Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулах

5.2.2. Хүний нөөцийг бүрдүүлэх, сул орон тоог нөхөх

5.2.3. Төрийн албан хаагчдын сургалт, хөгжүүлэлт

5.2.4. Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах

## **ЗУРГАА. ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА:**

### **6.1. Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулах (5.2.1 дэх зорилт)**

6.1.1. Албан хаагчдын ажиллах таатай орчныг бүрдүүлэх, өрөө тасалгааг тохижуулах, албан хэрэгцээнд ашиглагдах дэвшилтэт техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр үе шаттайгаар 100 хувь хангах.

6.1.2. Гамшгийн нөхцөл байдлын үед онцгой гавьяа байгуулсан болон урлаг, спортын уралдаан тэмцээнд (улс, бүс, аймаг)-ийн шагналт байранд орсон албан хаагчийг үндсэн цалингийн 20-50 хүртэлх хувиар шагнаж урамшуулна.

6.1.3. Албан хаагчдын ажиллах орчин нөхцөлийг сайжруулж, бодитой бүтээн байгуулалт хийсэн байгууллагыг жил бүр шалгаруулж, урамшуулах

6.1.4. Байгууллагадаа 3-аас доошгүй жил тогтвор суурьшилтай ажилласан төрийн албан хаагчийн тухайн жилийн ажлын гүйцэтгэл, хамт олны хурлын саналыг харгалзан удирдлагын шийдвэрээр жилд нэг удаа мөнгөн урамшуулал олгож болно. Урамшууллыг байгууллагын хөдөлмөрийн дотоод журмаар зохицуулна.

6.1.5. Олон нийтийн арга хэмжээнд идэвх зүтгэл, санал санаачилгатай оролцсон албан хаагчийг үндсэн цалингийн 20 хүртэлх хувиар шагнаж урамшуулна.

### **6.2. Хүний нөөцийг бүрдүүлэх, сүл орон тоог нөхөх (5.2.2 дахь зорилт)**

6.2.1. Хүн ам, нийгэм, эдийн засгийн өсөлтөөс хамаарч төрийн байгууллагын бүтэц, орон тоо нэмэгдэх хандлага, хүний нөөцийн стратегийн хэрэгцээгээ загварчлалаар тооцон гаргаж, тухайн жилийн хүний нөөцийн төлөвлөлтөд тусган, урьдчилан харж боловсон хүчнээ бэлтгэх

6.2.2. Судалгаанд үндэслэн ирээдүйд хэрэгцээт мэргэжилтэн бэлтгэхэд их, дээд сургууль, коллеж, тусгай мэргэжлээр суралцаж байгаа оюутны сургалтын төлбөрийн 100 хувийн тэтгэлэг олгож, тэтгэлэг олгосон жилээс хамаарч 2-4 хүртэл жил орон нутагтаа ажиллах нөхцөлтэйгөөр гэрээгээр мэргэжилтэн бэлтгэх.

6.2.2.1. Сургалтын төлбөрийн тэтгэлгийг орон нутагт хэрэгцээтэй мэргэжлээр суралцаж буй 2 оюутанд жилд 1 удаа олгоно.

6.2.3. Сул орон тоо үүсэх төсөөллийн судалгааг гаргаж хэрэгцээт мэргэжилтнийг тодорхойлж, хүний нөөцийн төлөвлөгөөнд тусгах.

6.2.4. Бүрэгхангай сумын оюутны холбооны тогтвортой байх, үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, хамтын ажиллагааг хөгжүүлэх.

### **6.3. Төрийн албан хаагчдын сургалт, хөгжүүлэлт (5.2.3 дахь зорилт)**

Мэргэжил олгох сургалтын зорилго нь ирээдүйд үүсэх сул орон тоонд төрийн албан хаагчийг бэлтгэх, мерит зарчмыг хэрэглэх үйл явц байна.

6.3.1. Шатлан дэвшүүлэх боломжтой, ажил байдлаараа манлайлагч төрийн албан хаагчийг сүүлийн 3 жилийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээгээр хангалттай сайн үнэлэгдсэн болон хамт олны саналыг харгалзан, удирдлагын санаачилгаар их, дээд сургуульд мэргэжил олгох сургалтад бодлогоор хамруулна.

6.3.2. Мэргэжил олгох сургалтад цалинтай эсвэл сургалтын төлбөрөөс 50-100 хувийг хариуцах гэх мэт хөшүүрэг хэрэглэж санхүүжилтийг байгууллагын тухайн жилийн хичээл, үйлдвэрлэлийн зардал, хүний нөөцийн дэд хөтөлбөрийн зардалд тусган хэрэгжүүлнэ.

6.3.3. Мэргэжил олгох сургалтад хамрагдах төрийн албан хаагчтай дөрвөөс доошгүй жил тогтвор суурьшилтай ажиллах гэрээ байгуулна.

6.3.4. Төрийн албан хаагчдаас мэргэшүүлэх сургалтад хамруулах.

6.3.4.1. Байгууллагын удирдах албан тушаалтныг бэлтгэх, эсвэл ажилтны ур чадварыг сайжруулах зорилгоор мэргэшүүлэх сургалтад харуулна.

6.3.4.2. Төрийн албан хаагчийг мэдлэг, ур чадвар, ажлын гүйцэтгэлийн үнэлгээг харгалзан менежерийн түвшний болон ур чадвар олгох сургалтад хамруулах.

6.3.5. Мэргэжил олгох, мэргэшүүлэх сургалтын хэрэгцээг жил бүр тодорхойлон тухайн жилийн хүний нөөцийн менежмент төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэхийг Төсвийн шууд захирагч хариуцна.

6.3.6. Байгууллагын удирдах албан тушаалтныг ур чадвар олгох болон удирдахуйн ухааны чиглэлээр 2 жилд нэг удаа сургалтад хамруулна.

6.3.7. Байгууллагын хөгжил, манлайлал, өөрчлөлтийн менежмент сэдэвт 8 кер/цагийн сургалтыг жил бүр авах. Энэ сургалтыг зохион байгуулах санхүүгийн эх үүсвэрийг орон нутгийн төсөвт тусган хэрэгжүүлэх.

6.3.8. Арван таваас дээш жил тогтвор суурьшилтай ажиллан онцгой гавьяа байгуулсан 2 ажилтныг дараах аль нэг хэлбэрээр урамшуулна

6.3.8.1. Гадаад улсад туршлага судлах богино хугацааны сургалт,

6.3.8.2. Гадаад улсад аялалд хамруулах,

6.3.8.3. Нэг хүүхдийн сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүлэх.

#### **6.4. Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах (5.2.4 дэх зорилт)**

6.4.1. Төрийн албан хаагчийн байр, орон сууц төсөл хэрэгжүүлэх

6.4.1.1. Хуучнаар ахуйн үйлчилгээний шар барилгыг дотор засвар хийж төрийн албан хаагчийн 5 айлын нийтийн орон сууц болгон тохижуулах.

6.4.1.2. Эрүүл мэндийн төвийн албан хаагчдын барилгыг их засвар хийж 100 хувь төрийн албан хаагчийн орон сууц болгон ашиглалтад оруулах.

6.4.1.3 Ерөнхий боловсролын сургуулийн 1-р хороон дахь сууцын их засвар хийх.

6.4.2. Төрийн албан хаагч өөрийн хөрөнгөөр хувийн сууц барихад нь зориулж 10 хүртэл сая төгрөгийг 1 жилийн хугацаатай хүүгүй зээл олгох.

6.4.3. Орон нутагт түрээсийн орон сууц барих боломжийг судлан барилга угсралтын компанитай хамтран ажиллах. Хувийн хэвшил, иргэний хооронд зуучлах, баталгаа гаргаж өгөх хэлбэрээр дэмжих.

6.4.4. Орон нутагт шинээр томилогдон ирсэн төрийн албан хаагчийг нийтийн байраар хангаж, эхний жилийн түрээсийн төлбөрөөс чөлөөлнө

6.4.5. Өөр аймаг сумаас ирж ажиллаж буй чухал шаардлагатай мэргэжилтэнтэй 3-5 жилийн тогтвортой ажиллах гэрээ байгуулан, мөнгөн дэмжлэг үзүүлэх.

6.4.6. Байгууллага бүрээс нэг албан хаагчийг хамт олны хурлаар дэмжвэл малжуулах төсөлд жил бүр хамруулна. Малжуулах төсөлд хамруулах болзол, журмаар энэ харилцааг зохицуулна.

6.4.7. Гэржүүлэх төслийн хүрээнд байгууллага бүрд 1 иж бүрэн гэр олгож орон байрны хэрэгцээ шаардлагатай байгаа албан хаагчдаа байгууллага өөрөө шийддэг боломжийг бүрдүүлнэ.

6.4.8. Төрийн албан хаагчийг эрт илрүүлэх шинжилгээнд жил бүр хамруулж ирэх очих шатахууны зардлын дэмжлэгийг хөтөлбөрөөс санхүүжүүлнэ.

#### **ДОЛОО.ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИХ ХУГАЦАА:**

7.1.Бүрэгхангай сумын Засаг даргын 2024-2028 оны “Хөгжлийг түүчээлье” үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулан таван жилийн хугацаанд (2025-2029 он) хэрэгжүүлнэ.

#### **НАЙМ. ДЭД ХӨТӨЛБӨРИЙН УДИРДЛАГА, САНХҮҮЖИЛТ:**

8.1. Хөтөлбөр хэрэгжүүлэх үе шат, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлттэй уялдуулан жил бүрийн 01 дүгээр сарын 20-ний дотор төрийн албаны хүний нөөцийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулан сумын Засаг даргаар батлуулна.

8.2. Хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ.

8.2.1. Улсын болон орон нутгийн төсөв

8.2.2.Төрийн байгууллагын төсөв, өөрийн орлого

8.2.3. Төсөл, хөтөлбөр

8.2.4. Байгууллага, аж ахуй нэгж, иргэдийн хандив, тусламж, дэмжлэг

6.2.5. Хуулиар хориглоогүй бусад эх үүсвэр

**ЕС. ГҮЙЦЭТГЭЛИЙГ ХЭМЖИХ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ:**

№	Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт
1	Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулах	Техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр хангагдсан байдал.	Хувиар
		Бүтээн байгуулалт хийсэн байгууллагын тоо	Бүтээн байгуулалтын тоогоор
		Албан хаагчийн тогтвор суурьшилтай ажиллаж байх байдал	Хувиар
2	Хүний нөөцийг бүрдүүлэх, сул орон тоог нөхөх	Химийн багш	Тоо
		Математикийн багш	Тоо
		Лаборант	Тоо
		Сувилагч	Тоо
		Бага ангийн багш	Тоо
	Байгаль хамгаалал	Тоо	
3	Төрийн албан хаагчдын сургалт, хөгжүүлэлт	Төрийн албан хаагчийг мэргэжил олгох сургалтад хамруулах	Тоо
		Төрийн албан хаагчийг мэргэжил олгох сургалтад хамруулах	Тоо
		Удирдах албан тушаалтны сургалт хамруулах	Тоо
4	Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах	Төрийн албан хаагчийн байр, орон сууцны хангалт	Тоо
		Төрийн албан хаагч түрээсийн орон сууцаар хангагдсан байдал	Тоо
		Мөнгөн дэмжлэгт хамрагдсан төрийн албан хаагчид	Тоо
		Малжуулах төсөлд хамрагдсан төрийн албан хаагчийн	Тоо
		Түрээсийн төлбөрөөс чөлөөлөгдсөн албан хаагчид	

**АРАВ.ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭХ ҮР ДҮН:**

10.1.Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрнэ.

10.1.1. Төрийн байгууллагуудын хүний нөөцийн төлөвлөлт, боловсон хүчний нөөц бүрдүүлэлт, сургаж дадлагажуулах ажлын зохион байгуулалт оновчтой болж, төрийн албаны мэргэшсэн тогтвортой байх чадахуйн зарчим хэрэгжинэ.

10.1.2. Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа, тогтвор суурьшил сайжирч, орон нутагт мэргэжлийн боловсон хүчний хангалт нэмэгдэнэ.

10.1.3. Төрийн албан хаагчдын мэдлэг, мэргэшил, ур чадвар дээшилж, ажлын гүйцэтгэл, бүтээмж сайжирна.

**АРВАННЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ:**

11.1. Хөтөлбөрийг төр, төсвийн байгууллагын төсвийн шууд захирагч хэрэгжилтийг зохион байгуулна.

11.2. Засаг даргын Тамгын газар удирдлага, зохицуулалтаар ханган, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийн дагуу жил бүр явцын үнэлгээг сумын Засаг даргын дэргэдэх Удирдах багт танилцуулна.

11.3. Дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийж 2 жил тутамд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанд тайлагнаж ажиллана.

---oOo---